

**ОРЛОГО БА ХӨРӨНГИЙН ТАТВАРЫГ ДАВХАРДУУЛЖ
НОГДУУЛАХГҮЙ БАЙХ, ТАТВАР ТӨЛӨХӨӨС ЗАЙЛСХИЙХ
ЯВДЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ БҮГД НАЙРАМДАХ
ПОЛЬШ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар, Монгол Улсын
Засгийн газар,

Санхүүгийн саад бэрхшээлийг арилгах замаар хоёр орны
хоорондын эдийн засгийн харилцааг хөхиүлэн дэмжиж, бэхжүүлэхийг
эрмэлзэн,

дараах зүйлийг хэлэлцэн тохиров. Үүнд:

1 дүгээр зүйл. Хамаарагдах этгээд

Энэхүү Хэлэлцээр нь Хэлэлцэн тохирогч хоёр Улс буюу тэдгээрийн аль нэгний нутаг дэвсгэрт байнга оршин суугч этгээдийг хамаарна.

2 дугаар зүйл. Хамаарагдах татварын төрлүүд

1. Хэлэлцэн тохирогч Улс, түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээс орлого ба хөрөнгөд ногдуулж буй татварууд нь тэдгээрийг хэрхэн ногдуулж байгаа хэлбэрээс үл шалтгаалан энэхүү Хэлэлцээрт хамаарна.

2. Орлого ба хөрөнгөд ногдуулж буй татвар гэж нийт орлого буюу нийт хөрөнгө болон орлого буюу хөрөнгийн бүрэлдэхүүн хэсэгт ногдуулж буй бүх төрлийн татвар түүний дотор хөдлөх ба үл хөдлөх хөрөнгийн борлуулалтын орлого, аж ахуйн нэгжээс олгож буй цалин хөлсний нийт хэмжээ болон хөрөнгийн үнэлгээний өсөлтийн орлогод ногдуулах татварыг хэлнэ.

3. Энэхүү Хэлэлцээр хэрэглэж буй дараах татваруудыг хамаарна:

а) Польшийн хувьд:

I/ хүн амын орлогын татвар,

II/ корпорацийн орлогын татвар, (цаашид "Польшийн татвар" гэнэ)

б) Монголын хувьд:

I/ хүн амын орлогын албан татвар,

II/ аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвар, (цаашид "Монголын татвар" гэнэ)

4. Энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурсан өдрөөс хойш шинээр бий болсон, одоогийн татварт нэмэлт болох буюу тэдгээрийг орлох татварууд нь 3 дугаар заалтад дурдсан татваруудтай адил буюу төстэй байвал энэхүү Хэлэлцээрт мөн хамаарна. Хэлэлцэн тохирогч Улсуудын эрх бүхий байгууллагууд нь өөрийн орны татварын хуульд орсон аливаа зарчмын нэмэлт өөрчлөлтийн талаар ийм нэмэлт өөрчлөлт оруулснаас хойш тодорхой хугацаанд харилцан мэдэгдэж байна.

3 дугаар зүйл. Ерөнхий тодорхойлолт

1. Энэхүү Хэлэлцээрт дорхи нэр томъёог өөрөөр заагаагүй бол дараах утгаар ойлгоно. Үүнд:

а) "Польш" гэж газар зүйн утгаар авч үзвэл олон улсын болон Польш Улсын хуулийн дагуу түүний хилийн усны гаднах далайн усыг оролцуулсан Бүгд Найрамдах Польш Улсын нутаг дэвсгэр, Польш Улс өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх далайн ёроол, түүний хэвлий болон тэдгээрийн байгалийн баялагийг хэлнэ,

б) “Монгол” гэж газар зүйн утгаар авч үзвэл Монгол Улсын нутаг дэвсгэр, Монгол Улсын татварын хууль үйлчлэх газар нутаг, түүнчлэн

олон улсын эрх зүйн дагуу байгалийн баялгийг нь Монгол Улс ашиглах бүрэн эрхээ хэрэгжүүлэх газар нутгийг хэлнэ,

в) “Хэлэлцэн тохирогч Улс” болон “Хэлэлцэн тохирогч нөгөө Улс” гэж тухайн заалтын утгаас хамааран Польш Улс болон Монгол Улсыг хэлнэ.

г) “татвар” гэж Хэлэлцээрийн заалтын утгаас хамааран Польшийн буюу Монголын татварыг хэлнэ,

д) “этгээд” гэж хувь хүн, компани болон аливаа бусад бүлэг этгээдийг хэлнэ,

е) “компани” гэж хуулийн эрх бүхий аливаа этгээд буюу татвар ногдуулах утгаараа түүнтэй адилтгах аливаа байгууллагыг хэлнэ,

ж) “Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгж” гэж тухайн энэ Улсад байнга оршин суугч этгээдийн эрхэлдэг аж ахуйн нэгжийг хэлнэ. “Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын аж ахуйн нэгж” гэж тухайн нөгөө Улсад байнга оршин суугч этгээдийн эрхэлдэг аж ахуйн нэгжийг хэлнэ,

з) “харъяат” гэж Хэлэлцэн тохирогч Улсын иргэн аливаа хувь хүн болон Хэлэлцэн тохирогч Улсын хүчин төгөлдөр хуулийн дагуу зөвшөөрөгдөн ажиллаж буй хуулийн аливаа этгээд, мөн түүнчлэн татвар ногдуулах утгаараа хуулийн этгээдтэй адил хуулийн эрхгүй байгууллагуудыг хэлнэ,

и) “олон улсын тээвэр” гэж Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгжээс хөлөг онгоц, нисэх онгоц, хуурай буюу төмөр замын тээврийн хэрэгслээр хийх аливаа тээврийн үйл ажиллагааг хэлнэ. Харин Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дахь цэгүүдийн хооронд хөлөг онгоц, нисэх онгоц, хуурай буюу төмөр замын тээврийн хэрэгслээр хийх тээврийн үйл ажиллагаа үүнд үл хамаарна,

к) “эрх бүхий байгууллага” гэж;

I) Польшийн хувьд Сангийн сайд буюу түүний эрх бүхий төлөөлөгчийг хэлнэ,

II) Монголын хувьд Сангийн сайд буюу түүний эрх бүхий төлөөлөгчийг хэлнэ.

2. Энэхүү Хэлэлцээрт тодорхойлогдоогүй аливаа нэр томъёог Хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол Хэлэлцээрт хамаарагдаж буй татвартай холбогдол бүхий Хэлэлцэн тохирогч Улсын хуульд зааснаар ойлгоно.

4 дүгээр зүйл. Байнга оршин суугч

1. Энэхүү Хэлэлцээрт “Хэлэлцэн тохирогч аль нэг Улсад байнга оршин суугч” гэж өөрөө болон голлох удирдлага нь байрлаж байгаа мөн түүнтэй адилтгах бусад шалтгаанаар оршин сууж, байрлаж тэр Улсын хуулийн дагуу тухайн Улсад татвар төлөх үүрэгтэй аливаа этгээдийг хэлнэ.

2. Энэхүү зүйлийн 1 дүгээр заалтын дагуу Хэлэлцэн тохирогч хоёр Улсын аль алинд нь байнга оршин суугч хувь этгээдийн статусыг дараах байдлаар тодорхойлно;

а) байнга амьдардаг орон гэр нь Хэлэлцэн тохирогч аль Улсад байгаагаар нь тэр Улсад байнга оршин суугч гэж тооцно. Хэрэв хувь этгээд нь Хэлэлцэн тохирогч хоёр Улсын аль алинд нь байнга амьдардаг орон гэртэй бол Хэлэлцэн тохирогч аль Улсад түүний хувийн ба эдийн засгийн харилцаа (язгуур эрх ашгийн төв) нь илүү ойр дөт байгаагаар нь тэндхийн байнга оршин суугч гэж тооцно,

б) хэрэв түүний язгуур эрх ашгийн төв бүхий Улсыг тодорхойлох аргагүй, эсвэл энэ хувь этгээд нь Хэлэлцэн тохирогч хоёр Улсын аль алинд нь байнга амьдардаг орон гэргүй бол Хэлэлцэн тохирогч аль Улсад түр орогнох байртай байгаагаар нь тэр Улсад байнга оршин суугч гэж тооцно,

в) хэрэв хувь этгээд нь Хэлэлцэн тохирогч хоёр Улсын аль алинд нь орогнох байртай, эсвэл алинд нь ч байхгүй бол түүнийг Хэлэлцэн тохирогч аль Улсын харъяат байгаагаар нь тэр Улсад байнга оршин суугч гэж тооцно,

г) хэрэв хувь этгээд нь Хэлэлцэн тохирогч хоёр Улсын аль алины харъяат эсвэл алиных нь ч харъяат биш бол асуудлыг Хэлэлцэн тохирогч Улсуудын эрх бүхий байгууллагууд хэлэлцэж шийдвэрлэнэ.

3. Энэхүү зүйлийн 1 дүгээр заалтын дагуу хувь хүнээс бусад хуулийн этгээд Хэлэлцэн тохирогч хоёр Улсын аль алинд нь байнга оршдог бол түүний голлох удирдлага нь Хэлэлцэн тохирогч аль Улсад байрлаж байгаагаар нь тэр Улсын байнга оршин суугч гэж тооцно.

5 дугаар зүйл. Төлөөлөгчийн газар

1. Энэхүү Хэлэлцээрт “Төлөөлөгчийн газар” гэж аж ахуйн нэгж өөрийн үйл ажиллагаагаа бүхэлд нь буюу хэсэгчлэн явуулдаг байнгын байрлалыг хэлнэ.

2. “Төлөөлөгчийн газар” гэдэгт тухайлбал;

а) аж ахуйг удирдан явуулж буй газар,

б) салбар байгууллага,

в) албан контор,

- г) үйлдвэр, завод,
 - д) цех, тасаг,
 - е) уурхай, газрын тос буюу байгалийн хийн цооног, ил уурхай буюу байгалийн аливаа бусад ашигт малтмал олборлож буй газар орно.
3. Зөвхөн 12 сараас дээш хугацаагаар үргэлжлэх барилгын талбай, барилга байгууламж, угсралт суурилалтын ажлыг "Төлөөлөгчийн газар" гэж тооцно.
4. 1, 2 ба 3 дугаар заалтуудыг үл харгалзан "Төлөөлөгчийн газар" гэдэгт дараах үйл ажиллагааг үл хамааруулна;
- а) аж ахуйн нэгж зөвхөн өөрийн бараа буюу эд агуурсыг хадгалах, үзэсгэлэнд тавих буюу нийлүүлэх зорилгоор аливаа байгууламж ашиглахыг,
 - б) аж ахуйн нэгж зөвхөн хадгалах, үзэсгэлэнд тавих, нийлүүлэх зорилгоор бараа буюу эд агуурс байлгахыг,
 - в) аж ахуйн нэгж өөр бусад аж ахуйн нэгжээр зөвхөн боловсруулалт хийлгэх зорилгоор бараа буюу эд агуурс байлгахыг,
 - г) аж ахуйн нэгжид зориулан бараа буюу эд агуурс зөвхөн худалдан авах буюу мэдээлэл цуглуулах зориулалтаар байнгын байрлал байлгахыг,
 - д) аж ахуйн нэгжийн байнгын бус хугацаагаар худалдаа-үзэсгэлэнд тавьсан бараа, эд агуурсыг уг худалдаа - үзэсгэлэнг хаагдсаны дараа борлуулахыг,
 - е) аж ахуйн нэгж сурталчилгаа хийх буюу мэдээллээр хангах, шинжлэх ухааны судалгаа хийх буюу эдгээртэй адил төстэй бэлтгэх, туслах чанартай үйл ажиллагаа явуулах зорилгоор байнгын байрлал байлгахыг.
5. Энэхүү зүйлийн 1 ба 2 дугаар заалтыг үл харгалзан 6 дугаар заалтад хамаарах бие даасан эрх бүхий төлөөлөгчөөс бусад этгээд Хэлэлцэн тохирогч Улсад Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын аж ахуйн нэгжийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж гэрээ (контракт) байгуулах эрх эдэлдэг бол уг аж ахуйн нэгжийг Хэлэлцэн тохирогч тэр Улсад төлөөлөгчийн газартай гэж үзнэ. Гэхдээ уг этгээдийн үйл ажиллагаа 4 дүгээр заалтад дурдсан үйл ажиллагаагаар хязгаарлагдан улмаар энэ ажиллагааг явуулж буй байр нь дээрх заалтын дагуу төлөөлөгчийн газар болж чадахгүй тохиолдолд уг аж ахуйн нэгжийг төлөөлөгчийн газартай гэж үзэхгүй.
6. Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгж Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад брокер, ерөнхий комиссын төлөөлөгч, бие даасан эрх бүхий бусад төлөөлөгчдөөр дамжуулан үйл ажиллагаа явуулж байгаа нь түүнийг

Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад төлөөлөгчийн газартай гэж үзэх үндэс болохгүй бөгөөд тэдгээр этгээд нь өөрийн тогтсон чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг байх нь үүний нөхцөл болно. Гэхдээ ийм төлөөлөгчийн үйл ажиллагаа нь бүхэлдээ буюу дийлэнхдээ уг аж ахуйн нэгжийн нэрийн өмнөөс хийгдэж байгаа бол түүнийг бие даасан эрх бүхий төлөөлөгч гэж энэхүү заалтад хамааруулахгүй.

7. Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршдог компани нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршдог, эсвэл Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад үйл ажиллагаагаа (төлөөлөгчийн газраар дамжуулан буюу бусад аргаар) явуулдаг компанийг хянадаг эсвэл хяналтад байдаг нь эдгээр компанийг бие биеийнх нь төлөөлөгчийн газар гэж үзэх үндэс болохгүй.

6 дугаар зүйл. Үл хөдлөх хөрөнгөнөөс орох орлого

1. Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугчийн Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байрладаг үл хөдлөх хөрөнгөнөөс олсон орлогод (хөдөө аж ахуй болон ойн аж ахуйгаас олсон орлогыг оролцуулан) Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар ногдуулж болно.

2. "Үл хөдлөх хөрөнгө" гэдгийг тухайн хөрөнгө байрлаж буй Хэлэлцэн тохирогч Улсын хуульд заасны дагуу тодорхойлно. Аль ч тохиолдолд уг нэр томъёонд үл хөдлөх хөрөнгөд дагалдах өмч, хөдөө аж ахуйн болон ойн аж ахуйд ашиглагдаж буй мал, тоног төхөөрөмж, газар оролцсон өмчийн талаарх хуулийн заалт хэрэглэгдэх эрх, бусдын үл хөдлөх хөрөнгийг эзэмшин ашиглах эрх, ашигт малтмалын нөөц, рашаан ус болон байгалийн бусад баялгийг ашигласны төлөө буюу ашиглах эрхийн төлөө төлөх байнгын бус болон тогтмол төлбөрийн эрхийг багтаана. Харин хөлөг онгоц, нисэх онгоц, хуурай буюу төмөр замын тээврийн хэрэгсэл үл хөдлөх эд хөрөнгөд үл тооцогдоно.

3. Энэхүү зүйлийн 1 дүгээр заалт нь үл хөдлөх хөрөнгийг шууд ашиглах, бусдад түрээслүүлэх, эсвэл бусад аль ч хэлбэрээр ашиглах замаар олсон орлогод хамаарна.

4. Энэхүү зүйлийн 1 болон 3 дугаар заалт нь аж ахуйн нэгжийн үл хөдлөх хөрөнгө, түүнчлэн бие даасан хувийн үйлчилгээнд ашигласан үл хөдлөх хөрөнгөнөөс олсон орлогод хамаарна.

7 дугаар зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны ашиг

1. Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгж нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын нутагт байрладаг төлөөлөгчийн газраар дамжуулан аж ахуйн үйл ажиллагаа эрхлээгүй тохиолдолд зөвхөн тэр Улсад татвар ногдуулна. Хэрэв аж ахуйн нэгж нь дээр дурдсан байдлаар үйл ажиллагаа эрхэлбэл уг аж ахуйн нэгжийн ашгийн зөвхөн дараах зүйлд хамаарах хэсэгт нөгөө Улсад татвар ногдуулна;

а) тухайн байнгын төлөөлөгчийн газарт,

б) тухайн байнгын төлөөлөгчийн газраар дамжуулан борлуулсантай адил төстэй бараа буюу эд агуурсыг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад борлуулсанд.

2. Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгж, Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын нутагт байрладаг өөрийн төлөөлөгчийн газраар дамжуулан аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй тохиолдолд уг төлөөлөгчийн газар нь төлөөлж буй аж ахуйн нэгжтэйгээ бүрэн бие даасан байдлаар харьцан адил, эсвэл төстэй үйл ажиллагаа, адил буюу төстэй нөхцөлд эрхлэн явуулж олж болох байсан ашгийг энэхүү зүйлийн 3 дугаар заалтын дагуу уг төлөөлөгчийн газрын ашиг гэж Хэлэлцэн тохирогч Улс бүрийн хувьд тооцно.

3. Төлөөлөгчийн газрын ашгийг тодорхойлохдоо аж ахуйн үйл ажиллагааг эрхлэн явуулахад тус төлөөлөгчийн газраас өөрийн оршин байгаа Хэлэлцэн тохирогч Улс болон бусад Улсад зарцуулсан аж ахуйн болон захиргааны зардлыг хасч тооцно.

4. Хэлэлцэн тохирогч Улсад аж ахуйн нэгж өөрийн салбарууддаа нийт орлогыг хуваарилдаг аргаар байнгын төлөөлөгчийн газрын орлогыг тодорхойлж хэвшсэн бол Хэлэлцэн тохирогч Улс энэ хэвшсэн аргаар татвар ногдох орлогыг тодорхойлоход энэхүү зүйлийн 2 дугаар заалт саад болохгүй. Гэхдээ хэвшсэн аргаар орлогыг хуваарилсантай холбогдон гарах үр дүн нь энэхүү зүйлийн зарчмуудтай зөрчилдөхгүй байвал зохино.

5. Аж ахуйн нэгж нь төлөөлөгчийн газраар дамжуулан бараа буюу эд агуурсыг зөвхөн худалдан авдаг бол үүнийг үндэслэн уг төлөөлөгчийн газрыг ашиг олсонд тооцож үл болно.

6. Энэхүү зүйлийн 1, 2, 3, 4 ба 5 дугаар заалтуудад нийцүүлэн төлөөлөгчийн газарт хамаарах ашгийг тодорхойлохдоо өөрчлөх баттай үндэслэлгүй бол жилээс жилд тогтсон нэг арга хэрэглэнэ.

7. Хэрэв аж ахуйн үйл ажиллагааны ашиг нь энэхүү Хэлэлцээрийн бусад зүйлд тусгайлан тодорхойлсон төрлийн орлогыг агуулсан бол тэдгээр зүйлийн заалтыг мөрдөхөд энэхүү зүйлийн заалтууд үл нөлөөлнө.

8 дугаар зүйл. Ус, агаар, хуурай болон төмөр замын тээвэр

1. Хэлэлцэн тохирогч Улсад голлох удирдлага нь байрладаг аж ахуйн нэгж хөлөг онгоц, нисэх онгоц, хуурай болон төмөр замын тээврийн хэрэгслээр олон улсын тээвэр хийж олсон ашигт зөвхөн Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулна.

2. Хэрэв усан замын тээврийн байгууллагын голлох удирдлага нь хөлөг онгоцон дээрээ байрладаг бол энэхүү хөлөг онгоцны харъяалах боомт оршдог Хэлэлцэн тохирогч Улсад, хэрэв харъяалах боомт үгүй бол уг хөлөг онгоцны эзэмшигч байнга оршин сууж байгаа Хэлэлцэн тохирогч Улсад голлох удирдлага нь байрладаг гэж үзнэ.

3. 1 дүгээр заалт нь пул, хамтарсан үйлдвэр болон олон улсын тээврийн ашиглалтын байгууллагын үйл ажиллагаанд оролцож олсон ашигт мөн хамаарна.

9 дүгээр зүйл. Хоршсон аж ахуйн нэгжүүд

Хэрэв:

а) Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгж Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын аж ахуйн нэгжийн удирдлага, хяналт болон хөрөнгөд шууд буюу шууд бусаар оролцдог бол, эсвэл

б) тухайн этгээдүүд хэлэлцэн тохирогч Улсын болон Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын аж ахуйн нэгжийн аль алиных нь удирдлага, хяналт болон хөрөнгөд шууд буюу шууд бусаар оролцдог бол,

тэдгээр хоёр нэгжийн хооронд тогтсон худалдаа, санхүүгийн харилцааны нөхцөл нь бие даасан аж ахуйн нэгжүүдийн хоорондын харилцааны нөхцлөөс ялгаатай бөгөөд тухайн аж ахуйн нэгжид ногдох ёстой аливаа ашиг дээрх ялгаатай нөхцлийн улмаас тооцогдоогүй байвал түүнийг уг аж ахуйн нэгжийн ашигт оруулан тооцож зохих журмын дагуу татвар ногдуулна.

10 дугаар зүйл. Дивиденд

1. Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршдог компаниас Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суугч этгээдэд төлж буй дивидендэд нөгөө Улс татвар ногдуулж болно.

2. Гэхдээ дивиденд төлж буй компани байнга оршдог Хэлэлцэн тохирогч Улсад тухайн дивидендэд өөрийн хууль тогтоомжийн дагуу татвар ногдуулж болох боловч дивиденд авагч этгээд нь түүний жинхэнэ эзэмшигч мөн бол ногдуулах татварын хэмжээ нь дивидендийн нийт дүнгийн 10 хувиас хэтрэх ёсгүй.

Энэхүү заалт нь тухайн компанийн дивиденд агуулсан ашигт ногдуулах татварт үл хамаарна.

3. Энэхүү зүйлд тусгагдсан "Дивиденд" гэж хувьцааны ногдол ашиг, өрийн нэхэмжлэлээс бусад хэлбэрээр ашигт оролцох эрхээс үүсэх орлого болон түүнтэй адилтгах бусад орлого, түүнчлэн хуваарилалт хийж буй компани байнга оршдог Хэлэлцэн тохирогч Улсын хуулийн дагуу хувьцааны ногдол ашигтай адилтган татвар ногдуулдаг бусад орлогыг хэлнэ.

4. Хэрэв дивидендийн эрхийг жинхэнэ эзэмшигч нь Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршдог бөгөөд дивиденд төлөгч компани байрладаг нөгөө Улсад төлөөлөгчийн газар буюу бие даасан хувийн үйлчилгээ эрхэлдэг товлосон газраар дамжуулан үйл ажиллагаа явуулдаг ба дивидендийн эрх хэрэг дээрээ энэ төлөөлөгчийн газар буюу товлосон газарт шууд хамааралтай бол 1 ба 2 дугаар заалтыг баримтлахгүй. Энэ тохиолдолд 7 буюу 14 дүгээр зүйлийн аль тохиромжтойг хэрэглэнэ.

5. Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршдог компани Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад ашиг буюу орлого олж байвал нөгөө Улс уг компанийн төлж буй дивидендэд татвар ногдуулахгүй байж болно.

Гэхдээ уг компаниас Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суугчид төлж байгаа дивиденд буюу дивиденд авах эрх нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дахь төлөөлөгчийн газар ба товлосон газартай шууд хамааралтай бол татвар ногдуулж болно. Харин компанийн хуваарилагдаагүй ашигт төлөгдсөн дивиденд буюу хуваарилагдаагүй ашиг нь бүхэлдээ буюу хэсэгчлэн нөгөө Улсад бий болсон ашиг орлогоос бүрэлдэж байлаа ч гэсэн татвар ногдуулахгүй байж болно.

11 дүгээр зүйл. Хуу

1. Хэлэлцэн тохирогч Улсад бий болж, Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суугч этгээдэд төлсөн хүүд нөгөө Улс татвар ногдуулж болно.

2. Гэхдээ хүү бий болсон Хэлэлцэн тохирогч Улс өөрийн хуулийн дагуу уг хүүд татвар ногдуулж болох боловч хэрэв уг хүүг хүлээн авагч нь түүний жинхэнэ эзэмшигч мөн бол ногдуулах татварын хэмжээ нийт хүүний 10 хувиас хэтрэх ёсгүй.

3. 2 дугаар заалтыг үл харгалзан Хэлэлцэн тохирогч Улсад бий болж Хэлэлцэн тохирогч Улсын Засгийн газар, түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болон төв банк буюу тэрхүү Засгийн газрын бүхэлд нь эзэмшдэг аливаа санхүүгийн байгууллагын авч байгаа хүү нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улс, түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болон төв банк буюу тэрхүү Засгийн газрын бүхэлд нь эзэмшдэг аливаа санхүүгийн байгууллагаас шууд бусаар санхүүжигдэж байгаа өрийн нэхэмжлэлтэй холбоотой бол эхний Хэлэлцэн тохирогч Улсад татвараас чөлөөлөгдөнө.

4. Энэхүү зүйлд тусгагдаж буй "хүү" гэсэн нэр томъёонд барьцаагаар баталгаажуулсан эсэх, зээлдэгчийн хөрөнгөнд оролцох эрхтэй эсэхийг үл харгалзан бүх төрлийн өрийн нэхэмжлэлээс үүссэн орлого, ялангуяа улсын зээллэгээ, бусад үнэт цааснаас орох орлого, мөн тэдгээрийн урамшууллын орлого орно. Харин төлбөр тооцоо хожимдуулсны торгууль нь энэхүү зүйлд дурдсан хүү гэж тооцогдохгүй.

5. Хэрэв хүү авах эрхийг жинхэнэ эзэмшигч нь Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршдог боловч Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад төлөөлөгчийн газраараа дамжуулан үйл ажиллагаа явуулж, тэнд нь энэ хүү бий болж байгаа, эсвэл нөгөө Улсад оршдог товлосон газраас хувийн бие даасан үйлчилгээ эрхэлдэг бөгөөд хүү авах эрх нь дурдсан төлөөлөгчийн газар буюу товлосон газартай шууд хамааралтай бол энэхүү зүйлийн 1, 2 ба 3 дугаар заалтыг мөрдлөгө болгохгүй. Энэ тохиолдолд 7 буюу 14 дүгээр зүйлийн аль тохиромжтойг хэрэглэнэ.

6. Хүү төлөгч нь Хэлэлцэн тохирогч Улс өөрөө, түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж буюу уг Улсын байнга оршин суугч бол хүүг Хэлэлцэн тохирогч Улсад бий болсон гэж үзнэ. Нөгөө талаар Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугч эсэхийг үл харгалзан хүүг төлөгч этгээд Хэлэлцэн тохирогч Улсад төлөөлөгчийн газар, эсвэл товлосон газартай бөгөөд үүнтэй холбогдон хүү төлөгдөж, уг хүү энэ төлөөлөгчийн газарт эсвэл товлосон газарт бий болж байгаа бол дээрх төлөөлөгчийн

газар, эсвэл товлосон газар оршиж байгаа Улсад хүү бий болсон гэж үзнэ.

7. Хэрэв хүү төлөгч болон хүү авах эрхийг жинхэнэ эзэмшигчийн хооронд мөн түүнчлэн тэдгээрийн болон ямар нэгэн хөндлөнгийн этгээдийн хоорондын онцлог харилцаанаас шалтгаалан төлж буй хүүгийн хэмжээ нь ийм харилцаа байхгүй байсан үед хүү төлөгч болон жинхэнэ эзэмшигч хоёр хоорондоо тохиролцож болох байсан хэмжээнээс хэтэрч байвал энэ зүйлийн заалтууд зөвхөн тохиролцож болох байсан хэмжээнд хамаарна. Энэ тохиолдолд хүүгийн төлбөрийн илүү гарсан зөрүүд Хэлэлцэн тохирогч Улс бүр өөрийн хуулийн дагуу энэхүү Хэлэлцээрийн бусад заалтыг харгалзан татвар ногдуулж болно.

12 дугаар зүйл. Эрхийн шимтгэл

1. Хэлэлцэн тохирогч Улсад бий болж, Хэлэлцэн тохирогч нөгөөУлсад байнга оршин суугчид төлж буй эрхийн шимтгэлд нөгөө Улсад татвар ногдуулж болно.

2. Гэхдээ Хэлэлцэн тохирогч Улсад бий болж байгаа эрхийн шимтгэлд тухайн улсын хуулийн дагуу татвар ногдуулж болох боловч уг эрхийн шимтгэлийг хүлээн авагч нь түүний жинхэнэ эзэмшигч мөн бол ийнхүү ногдуулж буй татвар нь эрхийн шимтгэлийн нийт хэмжээний 5 хувиас хэтрэх ёсгүй.

3. Энэхүү зүйлд хэрэглэгдэж буй “эрхийн шимтгэл” гэсэн нэр томъёонд уран зохиолын хэвлэн нийтлэх эрх, урлаг, уран сайхан болон шинжлэх ухааны бүтээл, түүний дотор уран сайхны кино, бусад кино, радио болон телевизийн нэвтрүүлэгт зориулсан бичлэг, патент, ноу-хау, барааны тэмдэг болон дизайн, үүний зэрэгцээ загвар, зураг төсөл болон нууц томъёолол буюу процессийг ашигласан буюу ашиглах эрх эдэлсэн, эсвэл үйлдвэрлэл, худалдаа буюу шинжлэх ухааны багаж хэрэгсэл, эсвэл үйлдвэр, худалдаа буюу шинжлэх ухааны туршлагатай холбогдсон мэдээллийг ашигласан буюу ашиглах эрх эдэлсний төлөө төлж буй бүх төрлийн төлбөр хамаарна.

4. Хэрэв эрхийн шимтгэлийг жинхэнэ эзэмшигч нь Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршдог боловч Хэлэлцэн тохирогч нөгөөУлс дахь төлөөлөгчийн газраар дамжуулан үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд тэнд энэхүү орлого бий болж байгаа, эсвэл Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад оршдог товлосон газраар дамжуулан бие даасан хувийн үйлчилгээ хийдэг түүнчлэн эрхийн шимтгэлийн төлбөр авах эрх буюу хөрөнгө нь хэрэг дээрээ энэхүү төлөөлөгчийн газар, эсвэл товлосон газарт шууд хамааралтай бол энэхүү зүйлийн 1 ба 2 дугаар заалтыг баримтлахгүй. Энэ тохиолдолд 7 буюу 14 дүгээр зүйлийн аль тохиромжтойг хэрэглэнэ.

5. Эрхийн шимтгэл төлөгч нь Хэлэлцэн тохирогч Улс өөрөө, түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж буюу уг Улсын байнга оршин суугч бол уг эрхийн шимтгэлийг Хэлэлцэн тохирогч Улсад бий болсон гэж үзнэ. Нөгөө талаар Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршин суудаг эсэхийг үл харгалзан эрхийн шимтгэлийн төлбөр төлөгч этгээд уг Хэлэлцэн тохирогч Улсад төлөөлөгчийн газар эсвэл товлосон газраар дамжуулан эрхийн

шимтгэлийн төлбөр төлөх үүрэг хүлээдэг бол тэрхүү төлөөлөгчийн газар эсвэл товлосон газрын оршиж байгаа Улсад эрхийн шимтгэлийг бий болсон гэж үзнэ.

6. Эрхийн шимтгэлийн төлбөр төлөх болон авах эрхийг жинхэнэ эзэмшигчид буюу тэдгээрийн болон бусад хөндлөнгийн этгээдийн хоорондын онцлог харилцаанаас шалтгаалан төлөгдсөн эрхийн шимтгэлийн хэмжээ нь ийм харилцаа байхгүй тохиолдолд түүнийг төлөгч ба жинхэнэ эзэмшигч хоёрын хоорондоо тохиролцож болох байсан хэмжээнээс хэтэрвэл энэхүү зүйлийн заалтууд зөвхөн тохиролцож болох байсан хэмжээнд хамаарна. Энэ тохиолдолд төлбөрийн илүү гарсан зөрүүд энэхүү Хэлэлцээрийн бусад заалтыг харгалзан Хэлэлцэн тохирогч Улс бүр өөрийн хуулийн дагуу татвар ногдуулна.

13 дугаар зүйл. Хөрөнгө борлуулсны орлого

1. Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугч Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байгаа энэхүү Хэлэлцээрийн 6 дугаар зүйлд хамаарах үл хөдлөх хөрөнгийг худалдаж борлуулснаас олсон орлогод нөгөө Улсад татвар ногдуулж болно.

2. Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгжийн Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дахь төлөөлөгчийн газрын үйл ажиллагаанд ашиглагддаг хөдлөх хөрөнгийн зарим хэсэг буюу Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугчаас Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад бие даасан хувийн үйлчилгээ явуулах зорилгоор ашиглаж буй товлосон газарт харъяалагдах хөдлөх хөрөнгийг худалдаж борлуулснаас орох орлого, мөн түүнчлэн ийм төлөөлөгчийн газар (дангаар эсвэл бүх аж ахуйн газрын хамт) буюу ийм товлосон газрыг худалдаж борлуулснаас орох орлогод нөгөө Улсад татвар ногдуулж болно.

3. Олон улсын шугамд ашиглагдаж буй хөлөг онгоц, нисэх онгоц, хуурай болон төмөр замын тээврийн хэрэгсэл буюу эдгээр хөлөг онгоц, нисэх онгоц, хуурай болон төмөр замын тээврийн хэрэгслийн үйл ажиллагаанд хамаарагдах хөдлөх хөрөнгө худалдаж борлуулснаас олсон орлогод ийм тээврийн хэрэгслийг ашиглаж буй тухайн аж ахуйн нэгжийн голлох удирдлага байрладаг Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулж болно.

4. Хөрөнгө нь шууд ба шууд бус байдлаар гол төлөв Хэлэлцэн тохирогч Улсад байрладаг үл хөдлөх хөрөнгөнөөс бүрддэг компаний хувь нийлүүлсэн хөрөнгийг худалдаж борлуулснаас олох орлогод уг үл хөдлөх хөрөнгө байрладаг Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулж болно.

14 дүгээр зүйл. Бие даасан хувийн үйлчилгээ

1. Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршин суугчаас мэргэжлийн үйлчилгээ үзүүлсэн, эсвэл бие даасан шинжтэй аливаа бусад үйл ажиллагаа эрхлэн олсон орлогод зөвхөн энэхүү Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулна. Гэхдээ уг орлогод дараах нөхцөлд Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар ногдуулж болно;

а) хэрэв байнга оршин суугч нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад өөрийн үйл ажиллагааг явуулахад байнга ашиглаж болох товлосон газартай бол Хэлэлцэн тохирогч нөгөө Улс түүний орлогын зөвхөн товлосон газарт хамаарах хэсэгт татвар ногдуулж болно,

б) хэрэв байнга оршин суугчийн Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад нийт байсан хугацаа нь тухайн хуанлийн жилийн 183 өдрөөс давсан бол Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад энэ хугацаанд явуулсан үйл ажиллагаанд ногдох орлогод Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар ногдуулж болно.

2. "Мэргэжлийн үйлчилгээ" гэж шинжлэх ухаан, уран зохиол, соёл урлаг, боловсрол болон багшлах бие даасан үйл ажиллагаа, түүнчлэн эмч, мэс засалч, хуульч, инженер, архитекторч, шүдний эмч болон нягтлан бодогч нарын бие даасан үйл ажиллагааг хэлнэ.

15 дугаар зүйл. Бие даасан бус хувийн үйлчилгээ

1. Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад ажил үйлчилгээ эрхлээгүйгээс бусад тохиолдолд Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугчийн ажил хийж авсан цалин хөлс болон түүнтэй адилтгах бусад шагнал урамшилд 16, 18 ба 19 дүгээр зүйлд заасанчлан зөвхөн Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулна. Хэрэв ажил үйлчилгээг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад гүйцэтгэж байгаа бол тэрхүү ажил үйлчилгээнээс олсон шагнал урамшилд нөгөө Улсад татвар ногдуулж болно.

2. Энэхүү зүйлийн 1 дүгээр заалтыг үл харгалзан Хэлэлцэн тохирогч Улсын оршин суугч Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад гүйцэтгэж буй ажил үйлчилгээний хөлсөнд олгосон шагнал урамшилд Хэлэлцэн тохирогч эхний Улсад дор дурдсан нөхцөлд татвар ногдуулна;

а) шагнал урамшил авагч нь аливаа 12 сарын хугацаанд нийтдээ 183 өдрөөс илүүгүй хугацаагаар Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байсан бол, мөн

б) шагнал урамшлыг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суудаггүй ажил олгогч өөрөө, эсвэл түүний нэрийн өмнөөс төлсөн бол, мөн

в) шагнал урамшлыг ажил олгогчийн Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дахь төлөөлөгчийн газар буюу товлосон газар нь төлөөгүй бол.

3. Энэхүү зүйлийн 1 ба 2 дугаар заалтуудыг үл харгалзан Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгжээс олон улсын шугамд тээвэр хийж буй хөлөг онгоц, нисэх онгоц, хуурай болон төмөр замын тээврийн хэрэгсэл дотор гүйцэтгэсэн ажил үйлчилгээнд зөвхөн тухайн аж ахуйн нэгжийн голлох удирдлага нь байрладаг Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулна.

16 дугаар зүйл. Захирлуудын шагнал урамшил

Хэлэлцэн тохирогч Улсын оршин суугч Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дахь компанийн Захирлуудын зөвлөл болон түүнтэй адилтгах байгууллагын гишүүний хувьд авсан цалин болон түүнтэй адилтгах бусад төрлийн шагнал урамшилд нөгөө Улсад татвар ногдуулж болно.

17 дугаар зүйл. Урлагийн ажилтнууд ба тамирчид

1. Энэхүү Хэлэлцээрийн 14 ба 15 дугаар зүйлийн заалтуудыг үл харгалзан Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршин суугч театр, кино жүжигчин, радио буюу телевизийн урлагийн ажилтан, хөгжимчин буюу тамирчин Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад хувийн тоглолт хийж олсон орлогод Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар ногдуулж болно.

2. 7, 14 ба 15 дугаар зүйлийн заалтуудыг үл харгалзан урлагийн ажилтан, тамирчны олсон орлого өөрт нь биш бусад этгээдэд ногдож байгаа тохиолдолд уг орлогод тоглолт болсон тухайн Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулна.

3. Энэхүү зүйлийн 1 ба 2 дугаар заалтыг үл харгалзан Хэлэлцэн тохирогч Улсад оршин суугч жүжигчин буюу тамирчны Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад Хэлэлцэн тохирогч хоёр Улсын Засгийн газрууд хоорондын соёлын солилцооны төлөвлөгөөний дагуу тоглолт явуулж олсон орлогыг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвараас чөлөөлнө.

18 дугаар зүйл. Тэтгэвэр

1. 19 дүгээр зүйлийн 2 дугаар заалтын дагуу Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршин суугч этгээдийн урьд хийж байсан ажилтай нь холбоотой олгосон тэтгэвэр болон түүнтэй адилтгах бусад төлбөрт зөвхөн тухайн Улсад татвар ногдуулна.

2. 1 дүгээр заалтыг үл харгалзан Хэлэлцэн тохирогч Улсын нийгмийн даатгалын системийн нэг хэсэг болох Засгийн газар буюу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн нийгмийн даатгалын сангаас олгож буй тэтгэвэр болон түүнтэй адилтгах бусад төлбөрт Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулна.

19 дүгээр зүйл. Засгийн газрын алба

1.

а) Хэлэлцэн тохирогч Улсын Засгийн газар буюу түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээс тэр Улсын Засгийн газар буюу түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид алба хашиж байсны хувьд хувь хүнд олгох тэтгэврээс бусад шагнал урамшилд зөвхөн тэр Улсад татвар ногдуулна.

б) гэхдээ уг хувь хүн нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад алба хашиж байгаа бөгөөд тэр Улсын байнга оршин суугч бол дараах тохиолдолд түүнд олгох шагнал урамшилд зөвхөн Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар ногдуулна. Уг хувь хүн;

II нөгөө Улсын харъяат бол,

III гагцхүү алба хаших үүднээс тэр Улсын байнга оршин суугч болоогүй бол.

2.

а) Хэлэлцэн тохирогч Улсын Засгийн газар буюу түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид алба хашиж байсны хувьд хувь хүнд Хэлэлцэн тохирогч Улсын Засгийн газар буюу түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн сангаас олгосон аливаа тэтгэвэрт зөвхөн тэр Улсад татвар ногдуулна.

б) гэхдээ уг хувь хүн нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын байнга оршин суугч бөгөөд тэр улсын харъяат нь бол дээр дурдсан тэтгэвэрт зөвхөн Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар ногдуулна.

3. Хэлэлцэн тохирогч Улсын Засгийн газар буюу түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээс аж ахуйн үйл ажиллагаа явуулахтай холбоотой алба хаасны хувьд олгосон шагнал урамшил болон тэтгэвэрт 15, 16 ба 18 дугаар зүйлүүд хамаарна.

20 дугаар зүйл. Багш нар болон судлаачид

Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын их сургууль, коллеж, сургууль, Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын их сургууль, коллеж, сургууль буюу тэр Улсын Засгийн газрын хүлээн зөвшөөрсөн боловсролын буюу эрдэм шинжилгээ судалгааны байгууллагад хичээл заах буюу судалгаа хийх үндсэн зорилгоор Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад ирэхийнхээ өмнө Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугч байсан буюу одоо хэвээр байгаа хувь хүний хичээл зааж, судалгаа хийж олсон аливаа шагнал урамшлыг нөгөө Улсад анх ирсэн өдрөөс эхлэн хоёр жилээс илүүгүй хугацаагаар нөгөө Улсад татвараас чөлөөлнө.

21 дүгээр зүйл. Оюутнууд болон дадлага хийгчид

Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад ирэхийнхээ өмнө Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугч байсан буюу одоо хэвээр байгаа бөгөөд Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад гагцхүү суралцах, дадлага хийх зорилгоор ирсэн оюутан, сурагч буюу дадлага хийгч өөрийгөө тэжээх, суралцах буюу дадлага хийхдээ зориулан олсон дараах тэтгэлэг буюу орлогыг нөгөө Улсад татвараас чөлөөлнө;

а) өөрийгөө тэжээх, суралцах, дадлага хийхэд зориулан Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын бус гадна эх үүсвэрээс авч байгаа тэтгэлэг,

б) Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад өөрийгөө тэжээх орлогоо нэмэгдүүлэх зорилгоор гүйцэтгэсэн хувийн үйлчилгээний орлого.

22 дугаар зүйл. Бусад орлого

1. Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугчийн олж буй энэхүү Хэлэлцээрийн өмнөх зүйлүүдэд хөндөгдөөгүй аливаа орлогод зөвхөн Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулна.
2. Хэрэв орлого ологч нь Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугч бөгөөд Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дахь төлөөлөгчийн газраараа дамжуулан үйл ажиллагаа явуулж байгаа буюу Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дахь товлосон газраар дамжуулан бие даасан хувийн үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд уг орлоготой холбогдсон эрх ба эд хөрөнгө нь энэ төлөөлөгчийн газар буюу товлосон газартай шууд холбоотой бол 6 дугаар зүйлийн 2 дугаар заалтад тодорхойлогдсон үл хөдлөх хөрөнгийн орлогоос бусад орлогын хувьд энэхүү зүйлийн 1 дүгээр заалтыг баримтлахгүй. Энэ тохиолдолд 7 буюу 14 дүгээр зүйлийн аль тохиромжтойг хэрэглэнэ.
3. 1 ба 2 дугаар зүйлийг үл харгалзан Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугчийн энэхүү Хэлэлцээрийн өмнөх зүйлүүдтэй холбогдолгүй орлогын төрлүүд нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад бий болсон бол уг орлогын төрлүүдэд Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар ногдуулж болно.

23 дугаар зүйл. Хөрөнгө

1. 6 дугаар зүйлийн 2 дугаар заалтад заасан үл хөдлөх хөрөнгөөр илэрхийлэгдсэн хөрөнгөд уг хөрөнгө байрлаж байгаа Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулж болно.
2. Аж ахуйн нэгжийн байнгын төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны хөрөнгийн зарим хэсгийг бүрдүүлэгч хөдлөх хөрөнгөөр илэрхийлэгдсэн буюу бие даасан хувийн үйлчилгээ явуулах зорилгоор ашиглаж буй товлосон газарт харъяалагдах хөдлөх хөрөнгөөр илэрхийлэгдсэн хөрөнгөд төлөөлөгчийн газар буюу товлосон газар байрладаг Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулж болно.
3. Олон улсын шугамд ашиглагдаж буй хөлөг онгоц, нисэх онгоц, хуурай болон төмөр замын тээврийн хэрэгсэлд болон уг хөлөг онгоц, нисэх онгоц, хуурай болон төмөр замын тээврийн хэрэгслийн үйл ажиллагаанд хамаарагдах хөдлөх хөрөнгөд тухайн аж ахуйн нэгжийн голлох удирдлага байрладаг зөвхөн тэр Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулна.
4. Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугчийн бусад бүх төрлийн хөрөнгөд уг хөрөнгө байрлаж байгаа зөвхөн тэр Улсад татвар ногдуулна.

24 дүгээр зүйл. Давхар татвар ногдуулахгүй байх

1. Польш Улсын хувьд давхар татварыг дараах байдлаар арилгана:
 - а) Польшийн байнга оршин суугч энэхүү Хэлэлцээрийн заалтын дагуу Монголд татвар ногдуулж болох орлого олж байгаа

буюу хөрөнгө эзэмшиж байгаа бол б) хэсэгт дурдсаны дагуу Польш энэхүү орлого буюу хөрөнгийг татвараас чөлөөлнө. Польш энэхүү байнга оршин суугчийн үлдэж байгаа орлого буюу хөрөнгөд татвар ногдуулахдаа чөлөөлсөн орлогыг чөлөөлөөгүй байхад ногдуулж болох байсан татварын хувь хэмжээг хэрэглэнэ,

б) Польшийн байнга оршин суугч энэхүү Хэлэлцээрийн 10, 11 ба 12 дугаар зүйлийн заалтад дурдсан Монголд татвар ногдуулж болох орлогын төрлүүдийг олж байвал Польш уг байнга оршин суугчийн орлогын татвараас Монголд төлсөн орлогын татвартай тэнцүү хэмжээний татварыг хасахыг зөвшөөрнө. Гэхдээ уг татварын хасах дүн нь хасахаас өмнөх Монголд олсон орлогын төрлүүдэд ногдох татварын тэр хэмжээнээс хэтрэхгүй байна.

в) Монголын тодорхой урамшлын тусгай арга хэмжээний дагуу чөлөөлсөн буюу бууруулсан татварын хэмжээгээр Монголд татвар төлсөн гэж тооцож Польшийн татвараас хасч тооцно.

2. Монгол Улсын хувьд давхар татварыг дараах байдлаар арилгана;

Монголын байнга оршин суугч энэхүү Хэлэлцээрийн заалтын дагуу Польшид татвар ногдуулж болох орлого олж байгаа буюу хөрөнгө эзэмшиж байгаа бол эдгээртэй холбоотой Польшид төлбөл зохих татварыг тухайн байнга оршин суугчид Монголын ногдуулсан татвараас хасч тооцож болно. Гэхдээ хөнгөлөлтийн дүн нь Монгол Улсын татварын хууль тогтоомжийн дагуу тухайн орлогод ногдуулсан Монголын татварын хэмжээнээс хэтрэхгүй байна.

25 дугаар зүйл. Ялгаварлан гадуурхах явдал гаргахгүй байх

1. Хэлэлцэн тохирогч Улсын харъяатыг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар төлөх болон түүнтэй холбоотой бусад шаардлагын хувьд Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын харъяатаас татварын адилгүй буюу илүү хүндрэлтэй нөхцөлд оруулахгүй.

2. Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгжийн Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байрладаг төлөөлөгчийн газрын татвар төлөх нөхцлийг нөгөө Улсын түүнтэй адилтгах төрлийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн татвар төлөх нөхцлөөс доогуур байлгаж болохгүй. Дээрх заалт нь Хэлэлцэн тохирогч Улс нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын байнга оршин суугчдыг иргэний эрх, гэр бүлийн хариуцлагын хувьд өөрийн байнга оршин суугчийн хувьд татвараас чөлөөлөх, хөнгөлөх, багасгах эрх эдлүүлэх ёстой гэсэн утгаар хэрэглэгдэхгүй.

3. 9 дүгээр зүйл, 11 дүгээр зүйлийн 7 дугаар заалт, 12 дугаар зүйлийн 6 дугаар заалтыг хэрэглэхээс бусад тохиолдолд Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгжийн татвар ногдох ашгийг тодорхойлохдоо тухайн аж ахуйн нэгжээс Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суугч этгээдэд төлж буй хүү, эрхийн шимтгэл болон бусад төлбөрийг эхний Улсын байнга оршин суугч этгээдэд төлсөнтэй адил нөхцлөөр хасна. Гэхдээ Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгжийн татвар ногдох хөрөнгийг тодорхойлохдоо тухайн аж ахуйн нэгжээс Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын байнга оршин суугчид төлсөн аливаа өрийг эхэнд дурдсан

Улсын байнга оршин суугчийн хувьд тохиролцсонтой адил нөхцлөөр хасч тооцно.

4. Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгжийн хөрөнгийг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын байнга оршин суугч нэг буюу хэсэг этгээд шууд буюу шууд бусаар бүхэлд нь, эсвэл хэсэгчлэн өмчилж буюу хянаж байвал Хэлэлцэн тохирогч Улс өөрийн адил төрлийн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн татвар төлөх буюу түүнтэй холбоотой шаардлагаас өөр буюу илүү хүндрэлтэй байдалд оруулах хариуцлага ногдуулахгүй.

5. 2 дугаар зүйлийг үл харгалзан энэхүү зүйлийн заалтууд нь аливаа татваруудад хамаарна.

26 дугаар үйл. Харилцан тохирох журам

1. Хэрэв хувь этгээд Хэлэлцэн тохирогч аль нэг Улс буюу хоёр Улс хоёулаа энэхүү Хэлэлцээрт заагдаагүй татвар түүнд ногдуулсан буюу ногдуулах боллоо гэж үзвэл тухайн Улсуудын дотоодын хууль тогтоомжийн заалтуудыг үл харгалзан өөрийн байнга оршин суугаа Хэлэлцэн тохирогч Улсынхаа эрх бүхий байгууллагад буюу 25 дугаар зүйлийн 1 дүгээр заалтад хамаарч байвал өөрийн харъяат Хэлэлцэн тохирогч Улсад гомдлоо гаргаж болно. Гомдлыг энэхүү Хэлэлцээрт заагдаагүй татвар ногдуулж байна гэж анх мэдсэнээс хойш 3 жилийн дотор гаргана.

2. Гомдлыг нотлож хангалттай шийдвэр гаргах боломжгүй бол Хэлэлцэн тохирогч хоёр Улсын эрх бүхий байгууллага энэхүү Хэлэлцээрт заагдаагүй татвар ногдуулахгүй байх зорилгоор харилцан тохирох бүх арга хэмжээ авна. Аливаа тохиролцоог Хэлэлцэн тохирогч Улсуудын хууль тогтоомжийн цаг хугацааны хязгаарлалтыг үл харгалзан хэрэгжүүлнэ.

3. Хэлэлцэн тохирогч Улсуудын эрх бүхий байгууллагууд нь энэхүү Хэлэлцээрийг хэрэглэх болон тайлбарлахад үүсэх аливаа хүндрэлтэй болон эргэлзээтэй асуудлуудыг харилцан тохирох замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Мөн түүнчлэн энэхүү Хэлэлцээрт заагдаагүй орлогыг давхар татвараас чөлөөлөх асуудлыг тэд хамтран шийдвэрлэж болно.

4. Хэлэлцэн тохирогч Улсуудын эрх бүхий байгууллагууд нь 2 ба 3 дугаар заалтын талаар тохиролцоонд хүрэх зорилгоор өөр хоорондоо шууд харилцаж болно. Хэрэв шаардлагатай бол тохиролцоонд хүрэхийн тулд Хэлэлцэн тохирогч Улсуудын эрх бүхий байгууллагуудын төлөөлөгчид санал солилцох зорилгоор биечлэн уулзаж болно.

27 дугаар зүйл. Харилцан мэдээлэл солилцох

1. Хэлэлцэн тохирогч хоёр Улсын эрх бүхий байгууллагууд энэхүү Хэлэлцээрт хамрагдах татварын талаарх хоёр Улсын хууль тогтоомж болон уг Хэлэлцээрийн заалтуудыг биелүүлэхэд шаардагдах мэдээллийг харилцан солилцож байна. Хоёр улсын татварын талаарх хууль тогтоомж, татвар ногдуулалт нь энэхүү Хэлэлцээр түүний дотор татвар

төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд харшлах ёсгүй. Харилцан мэдээлэл солилцох явдлыг 1 дүгээр зүйлээр хязгаарлахгүй. Хэлэлцэн тохирогч Улс Хэлэлцэн тохирогч нөгөө Улсаас хүлээн авсан мэдээллийг Хэлэлцэн тохирогч Улс өөрийн улсын мэдээлэл хадгалах хуулийн дагуу нууцалж зөвхөн энэхүү Хэлэлцээрт хамаарагдах татварын хэмжээг тогтоох буюу хураахтай холбогдсон этгээдүүд, эрх барих байгууллагуудад (шүүх, захиргааны байгууллагыг оролцуулан) мэдэгдэх эрхтэй. Тэдгээр этгээд буюу эрх барих байгууллагууд нь уг мэдээллийг зөвхөн энэхүү зорилгод ашиглана. Түүнчлэн тэд дээрх мэдээллийг олон нийтийн шүүхийн протокол, шүүхийн шийдвэрт тусгаж болно.

2. 1 дүгээр зүйлийн заалтууд нь ямар ч тохиолдолд Хэлэлцэн тохирогч Улсад дараах үүргийг хүлээлгэх ёсгүй;

- а) Хэлэлцэн тохирогч Улсуудын хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээнд харшлах захиргааны арга хэмжээ хэрэгжүүлэх,
- б) Хэлэлцэн тохирогч Улсуудын хууль тогтоомж болон захиргааны ердийн үйл ажиллагааны дагуу олж үл болох мэдээлэл буюу баримт бичгээр хангах,
- в) Хэлэлцэн тохирогч Улсуудын аливаа худалдаа, бизнес, аж үйлдвэр, арилжааны буюу мэргэжлийн нууц алдагдуулах мэдээ болон нийгмийн хэв журамд харшлах мэдээллээр хангах.

28 дугаар зүйл. Дипломат ба консулын ажилтнууд

Энэхүү Хэлэлцээр нь олон улсын эрх зүйн ерөнхий хэм хэмжээ болон тусгай хэлэлцээрийн заалтуудын дагуу дипломат ба консулын ажилтнуудын санхүүгийн эрх дархыг үл хөндөнө.

29 дүгээр зүйл. Хүчин төгөлдөр болох

1. Хэлэлцэн тохирогч Улсууд энэхүү Хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгоход шаардлагатай Үндсэн хуулийн шаардлагыг биелүүлсэн тухайгаа харилцан мэдэгдэнэ.

2. 1 дүгээр заалтад дурдсаны дагуу сүүлчийн ийм мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дараа энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болох бөгөөд түүний заалтууд доор заасны дагуу үйлчилж эхлэнэ;

- а) Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон жилийн дараагийн хуанлийн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдөр болон түүний дараагийн өдрөөс эхлэн эх үүсвэрт нь суутгалаар төлсөн буюу хөнгөлсөн зохих татварууд,
- б) Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон жилийн дараагийн хуанлийн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдөр болон түүний дараагийн өдрөөс эхлэн аливаа татварын жилд төлбөл зохих бусад татваруудад.


30 дугаар зүйл. Дуусгавар болох

Энэхүү Хэлэлцээрийг Хэлэлцэн тохирогч аль нэг Улс цуцлах хүртэл хүчин төгөлдөр мөрдөнө. Энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш 5 жилийн дараах хуанлийн жил дуусахаас 6 сараас өмнө уг Хэлэлцээрийг цуцлах тухайгаа Хэлэлцэн тохирогч аль ч Улс дипломат шугамаар, бичгээр мэдэгдэж болно. Энэ тохиолдолд энэхүү Хэлэлцээр доор заасан татваруудын хувьд хүчин төгөлдөр байхаа болино;

а) бичгээр мэдэгдэл өгсөн жилийн дараагийн хуанлийн жилийн 1 дүгээр сарын 1 -ний өдөр болон түүний дараагийн өдрөөс эхлэн эх үүсвэрт нь суутгалаар төлсөн буюу хөнгөлсөн зохих татварууд,

б) бичгээр мэдэгдэл өгсөн жилийн дараагийн хуанлийн жилийн 1 дүгээр сарын 1 -ний өдөр болон түүний дараагийн өдрөөс эхлэн аливаа татварын жилд төлбөл зохих бусад татварууд.

Энэхүү Хэлэлцээрийг Варшав хотноо 1997 оны 4 дүгээр сарын 18 -ны өдөр польш, монгол, англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна. Тайлбарлахад зөрүү гарвал англи хэлээрх эх бичвэрийг баримтлана.



БҮГД НАЙРАМДАХ ПОЛЬШ
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ